



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 61

Мөрөн

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дулааны станцын ашиглалтын өмнөх захиргааны үйлдвэрлэл болон санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, өвөлжилтийн бэлтгэлийн талаар санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

М.Очирхуяг /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд:

М.Пүрэвсүрэн / Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, аймгийн ИТХ-ын дэргэдэх Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны гишүүн/

Ж.Эрдэнэчимэг /Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга/

Б.Батбаяр /Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн/

Ч.Цэрэнсүрэн /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч/

Г.Баасанжав /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн/

Ч.Хуншагай /“Хөвсгөл Дулаан” ХХК-ийн захирал/

О.Төмөрхуяг /Дулааны станцын ашиглалтын өмнөх захиргааны ерөнхий инженер/

П.Чинчулуун /“Хөвсгөл Дулаан” ХХК-ийн ерөнхий инженер/

Д.Отгонбаяр /“Хөвсгөл-Эрчим Хүч” ХХК-ийн ерөнхий инженер/

Г.Энхбаяр /“УСНААК” ОНӨҮГ-ын ерөнхий инженер/

Г.Цээпил /аймгийн Иргэний нийгмийн байгууллагын тэргүүн/

Нарийн бичгийн дарга:

Д.Лхагвасүрэн /Аймгийн ИТХ-ын ажлын албаны Төсөв санхүү, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга/

2. Үйлдвэрлэл болон санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх санал, дүгнэлтийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны дотор багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, захиалагчид хүргүүлэхийг /ажлын хэсгийн дарга/ М.Очирхуягт даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг /аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/ С.Цогтоод үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БОЛДБААТАР